



ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

2020 оны 09 дүгээр
сарын 22-ны өдөр

Дугаар...
2012
1120/956

Улаанбаатар
хот

Нэг талаас Монголбанк /цаашид “Монголбанк” гэх/, түүнийг төлөөлж Олон нийтийн боловсрол, мэдээллийн төвийн захирал Б.Одонтунгалаг, нөгөө талаас Монгол Улсын Их сургууль /цаашид “МУИС” гэх/, түүнийг төлөөлж Шинжлэх Ухааны Сургуулийн захирал Д.Заяабаатар болон Бизнесийн сургуулийн захирал Ч.Энхбаяр нар /цаашид хамтад нь “талууд” гэх/ үйл ажиллагааны зорилго, зорилгод үндэслэн харилцан тохиролцож, хамтран ажиллахаар энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл, хугацаа

- 1.1. Энэхүү гэрээгээр Монголбанкнаас эдийн засаг, санхүүгийн чиглэлийн судалгаа, сургалтыг дэмжих “Тинк банк” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай талуудын хамтын ажиллагаа, оролцоог зохицуулна.
- 1.2. Гэрээний зорилго нь Эдийн засаг, санхүүгийн шинжлэх ухааныг хөгжүүлэх, сурталчлах чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хамтран хэрэгжүүлэх, тус салбарт өрсөлдөх чадвар бүхий судлаач, мэргэжилтэн бэлтгэхэд оршино.
- 1.3. Талууд хамтран ажиллахдаа Монгол Улсын Иргэний хуулийн 476-480 дугаар зүйл болон холбогдох бусад хууль эрх зүйн актыг удирдлага болгон байгууллага хоорондын харилцааны зохистой хэм хэмжээг эрхэмлэн, харилцан санал солилцох, зөвшилцөх, эрх тэгш байдлыг эрхэмлэх, нээлттэй, ил тод байх, үр бүтээлтэй байх зарчмуудыг баримтална.
- 1.4. Гэрээ нь батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөх бөгөөд 3 жилийн хугацаатай байна.

Хоёр. Хамтын ажиллагааны гол нөхцөл

- 2.1 Талууд эдийн засаг, санхүүгийн чиглэлээр судалгааны магистрын түвшний оюутныг жил бүр хамтран шалгаруулна.
 - 2.1.1 Судалгааг МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Эдийн засгийн тэнхимийн 5, Бизнесийн сургуулийн Санхүүгийн тэнхимийн 5 оюутнаар хийлгэнэ.
 - 2.1.2 Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд гарах зардлыг Монголбанк хариуцна.
- 2.2 Талууд эдийн засаг, санхүүгийн чиглэлээр ахисан түвшний судалгаа, эрдэм шинжилгээний ажлыг хамтран хийнэ.
- 2.3 Монголбанкны мэдээллийн цагийг талууд хамтран зохион байгуулна.
- 2.4 Талууд хамтран судалгааны хэлэлцүүлэг, уулзалтыг зохион байгуулна.

- 2.5 Талууд иргэдийн эдийн засаг, санхүүгийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн товхимол, гарын авлага гаргаж, сургалт хэлэлцүүлэг хамтран зохион байгуулна.
- 2.6 МУИС-иас эдийн засаг, санхүүгийн чиглэлээр суралцаж буй оюутнуудыг үйлдвэрлэлийн дадлага хийлгэх замаар сургалт үйлдвэрлэлийг уялдуулах,
- 2.7 Хамтын ажиллагаатай холбогдох мэдээллийг талууд өөрсдийн цахим хуудсанд байршуулах, тогтмол шинэчлэх.

Гурав. Талуудын эрх үүрэг

3.1 Монголбанкны эрх, үүрэг

- 3.1.1 Хууль буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөгөө талаас шаардах эрхтэй.
- 3.1.2 Нөгөө талаас хамтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн, бодитой, ямар нэгэн хязгаарлалтгүйгээр авах эрхтэй.
- 3.1.3 Гэрээг байгуулах үеийнхээс нөхцөл байдал өөрчлөгдөж, анх гэрээгээр тохирсон зохицуулалт нь цаашид боломжгүй болсныг баталж байгаа бол тухайн гэрээний агуулгыг өөрчлөгдсөн харилцаанд тохируулахыг шаардах эрхтэй.
- 3.1.4 2.1-д заасан хамтын ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих эрхтэй.
- 3.1.5 2.1-д заасан хамтын ажиллагааны хүрээнд Монголбанкны докторын зэрэгтэй ажилтан хичээл заах, судалгааны магистрын диплом удирдах эсвэл зөвлөхөөр ажиллах эрхтэй.
- 3.1.6 Гэрээний үүрэг зөрчигдсөн тохиолдолд хамтын ажиллагааны хүрээнд гарсан зардлыг МУИС-аас нэхэмжлэх эрхтэй.
- 3.1.7 Талуудын хамтран хийх судалгааны сэдвийг сонгож, санхүүжилтийг олгох эрхтэй.
- 3.1.8 Гэрээ хэрэгжих хугацаанд хамтын ажиллагааны гол нөхцөлүүдийн биелэлтийг бүрэн хангаж ажиллах үүрэгтэй.
- 3.1.9 2.1-д заасан хамтын ажиллагааны сонгон шалгаруулах комиссод магистр болон түүнээс дээш зэрэгтэй мэргэжилтэн оруулан ажиллуулах үүрэгтэй.
- 3.1.10 Шаардлагатай тохиолдолд 2.1-т шалгарсан оюутныг Монголбанкин дээр дадлага хийлгэх үүрэг хүлээнэ.

3.2 МУИС-ийн эрх, үүрэг

- 3.2.1 Хууль буюу гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг нөгөө талаас шаардах эрхтэй.
- 3.2.2 Нөгөө талаас хамтын үйл ажиллагааны талаарх мэдээллийг бүрэн, бодитой, ямар нэгэн хязгаарлалтгүйгээр авах эрхтэй.
- 3.2.3 Гэрээг байгуулах үеийнхээс нөхцөл байдал өөрчлөгдөж, анх гэрээгээр тохирсон зохицуулалт нь цаашид боломжгүй болсныг баталж байгаа бол тухайн гэрээний агуулгыг өөрчлөгдсөн харилцаанд тохируулахыг шаардах эрхтэй.
- 3.2.4 2.1-д заасан хамтын ажиллагааны хэрэгжилтэд Монголбанктай хамтран хяналт тавьж ажиллах үүрэгтэй.
- 3.2.5 2.1-т шалгарсан оюутныг суралцах нөхцлөөр бүрэн хангах үүрэг хүлээнэ.
- 3.2.6 2.1-д заасан хамтын ажиллагааны хэрэгжилтийг хангах хүрээнд мэргэжлийн хичээлийг олон улсын эрдэм шинжилгээний индекстэй (Жишээ нь Web of Science, Scopus гэх мэт) сэтгүүлүүдэд бүтээлээ хэвлүүлсэн, мэргэжлийн өндөр ур чадвартай багш нараар заалгаж, оюутны судалгааны ажлыг удирдуулна.
- 3.2.7 2.1-т шалгарсан магистрант нь Монголбанкнаас санал болгож буй сэдвүүдээс сонгож дипломын ажлаа бичих үүрэгтэй.
- 3.2.8 2.1-т шалгарсан магистрант нь Монголбанкнаас санал болгож буй эрдэм шинжилгээний хурал, хэлэлцүүлэгт оролцож, судалгааны үр дүнгээ танилцуулах үүрэгтэй.

- 3.2.9 2.1-т шалгарсан магистранттай үр дүн, хариуцлагын гэрээ байгуулан, хяналт тавин ажиллах үүрэгтэй.
- 3.2.10 Гэрээ хэрэгжих хугацаанд хамтын ажиллагааны гол нөхцлүүдийн биелэлтийг хангаж ажиллах үүрэгтэй.

Доров. Хариуцлага

- 4.1 Хууль болон гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөнөөс хамтын үйл ажиллагаа буюу нөгөө талдаа хохирол учруулсан тохиолдолд уг хохирлыг гэм буруутай тал нь хөрөнгөөрөө бүрэн хариуцан арилгах үүрэгтэй.
- 4.2 Талуудын аль нэг нь хамтын үйл ажиллагаатай холбоотой аливаа чухал шийдвэрлэх асуудлын талаар гэрээний нөгөө талд урьдчилан мэдэгдэж, бичгээр зөвшөөрөл авах ёстой.
- 4.3 Зайлшгүй зөвшөөрөл авах буюу хамтын шийдвэр гаргах асуудлыг зөвшөөрөл авалгүйгээр шийдвэрлэснээс үүдэн гарах аливаа хохирлыг дур мэдэн шийдвэрлэсэн тал бүрэн хариуцна.

Тав. Нууцлал хадгалах

- 5.1 Талууд нь хамтын үйл ажиллагааны явцад олж авсан нөгөө талын байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээ, мэдээллийг бусдад задруулахгүй бөгөөд хугацаагүйгээр нууцлах үүрэгтэй.
- 5.2 Талууд гэрээний үүргээ биелүүлэх явцад олж авсан мэдээ, мэдээллийг бусдад задруулсан, мэдээлсэн, хувилсан, дамжуулсан буюу эдгээр үйлдлийг хийхийг завдсан нөхцөлд байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, Эрүүгийн хууль болон холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээнэ.

Зургаа. Гэрээ дуусгавар болох үндэслэл

- 6.1 Гэрээ дараах үндэслэлээр дуусгавар болно.
- 6.1.1 Хамтын үйл ажиллагаа амжилттай хэрэгжиж, гэрээний хугацаа дуусгавар болсон;
- 6.1.2 Талууд гэрээг дуусгавар болгох тухай харилцан тохиролцсон;
- 6.1.3 Гэрээний аль нэг тал хууль буюу гэрээнд заасан үндэслэлээр гэрээг цуцалсан.
- 6.2 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй дараах тохиолдолд гэрээг цуцлах эрхтэй.
- 6.2.1 Талуудын аль нэг нь итгэлийг алдсан гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй гаргасан;
- 6.2.2 Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ өөрөө биечлэн гүйцэтгээгүй буюу бусдад дур мэдэн шилжүүлсэн.
- 6.2.3 Талууд гэрээнд заасан ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа өөрийн буруугаас нөгөө талдаа эд хөрөнгийн ноцтой хохирол учруулсан, Хөдөлмөрийн дотоод журмыг зөрчсөн.
- 6.2.4 Талууд хамтран ажиллах явцдаа олж мэдсэн мэдээ, мэдээллийг задруулсан, задруулахаар завдсан.
- 6.2.5 Хуульд заасан бусад үндэслэл.

Долоо. Бусад зүйл

- 7.1 Гэрээ нь 3 хувь үйлдэгдэх бөгөөд хууль зүйн адил хүчинтэй байна.
- 7.2 Гэрээ нь талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, батлах эрх бүхий албан тушаалтан баталж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

- 7.3 Талууд харилцан тохиролцож гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчин төгөлдөр үйлчилнэ. Нэмэлт, өөрчлөлтийг талууд гарын үсэг зурж, тэмдэг дарж гэрээнд хавсаргана.
- 7.4 Гэрээтэй холбоотой гарсан аливаа баримт бичиг нь энэхүү гэрээний салшгүй хэсэг болно.
- 7.5 Аль нэг тал дангаараа гэрээнд өөрчлөлт оруулахыг хориглоно.
- 7.6 Гэрээний хугацаа дууссан тохиолдолд гэрээ дуусгавар болно.
- 7.7 Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд гэрээг аль нэг талын санаачилгаар цуцлах эрхтэй ба энэ талаараа харилцан бие биедээ ажлын 15 хоногийн өмнө бичгээр мэдэгдэнэ.
- 7.8 Талууд энэхүү гэрээнд дурдаагүй асуудлыг шийдвэрлэхэд Монгол улсын хууль тогтоомжийг удирдлага болгоно.
- 7.9 Энэ гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэх бөгөөд тийнхүү тохиролцож чадаагүй тохиолдолд Монгол Улсын харьяалагдах шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:




ХЛЯГ:

Бага тойруу 3, 15160 Улаанбаатар-46,
Монгол Улс
Утас: 976-11-310081
Факс: 976-11-311471
info@mongolbank.mn/



Д.Заяабаатар

Бизнесийн сургуулийн захирал



Ч.Энхбаяр

ХЛЯГ:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Бага тойруу, Их сургуулийн гудамж-1
Утас: 75754400
news@num.edu.mn